

“Галт тэрэгний хөдөлгөөн
зохицуулалтын нэгдсэн төв”
УТҮГ-ын дотоод хэрэгцээнд
зориулан бэлтгэв.

МХХ-ны гишүүн
хуульч М.Үүрийнтуяа



Авлигын эсрэг хууль

БА ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ



Авлигын эсрэг хуулийн тухай



Ёс зүйн зөрчил, хүлээх хариуцлага



Ёс зүй, ёс суртахууны тухай

Авлигын эсрэг

хууль /2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан 6 бүлэг 35 зүйл бүхий тус хууль нь 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж эхэлсэн./

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн байгууллагын удирдах албан тушаалтан нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т зааснаар хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон **өдрөөс хойш 30** хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа **жил бүрийн 02 дугаар сарын 15-ны** дотор шинэчлэн гаргаж АТГ-т өгөх үүрэгтэй.

Тус хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь **/105.000.000 төгрөг/** дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлэх үүрэгтэй.



Хариуцлага

Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн тохиолдолд гаргасан зөрчлөөс хамаарч **сануулах,**


Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар **30 хувиар бууруулах,** албан тушаалаас нь **огцруулах буюу ажлаас халах**

Цаашлаад тус зөрчил нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжтэй бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах субъект нь хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглодог. Үүнд:

-
- ❖ Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;
 - ❖ Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
 - ❖ Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

- 
- ❖ Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
 - ❖ Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;

- ❖ Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- ❖ Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- ❖ Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

Төрийн албан хаагчийн ёс зүй

Ёс зүй хэмээх ойлголт нь хууль эрх зүй хэмээх ойлголтоос өргөн хүрээтэй бичигдээгүй хууль буюу зан заншил, уламжлал, соёл хэлбэрээр оршин тогтнож ирсэн онцлогтой. Харин орчин үед төрийн албанд хууль, дүрэм журмаар зохицуулагдаж байна.

Ёс суртахуун нь хувь хүний нийгмийн харилцаан дахь үйл хөдлөлийг тодорхойлогч, иргэнийг нийгэмшүүлэгч тулгуур хүчин зүйл юм.

Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэх нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зорилт юм.

Энэхүү хууль нь **2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр** батлагдаж хүчин төгөлдөр болсон.

Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг үүргээс

- Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх
- Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх
- Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн бүтэц, зохицуулалт

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
- Ёс зүйн хороо, ёс зүйн дэд хороо нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллах
- Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх

Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх

- Гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;
- Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах.



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА
